



АШУУИС  
1942

**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 1/147

Улаанбаатар хот

Багш, эмч, сувилагч, ажилтан,  
албан хаагчдын сонгон шалгаруулалтын  
журам батлах тухай

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дүрмийн 1.3, 4.8.1, 4.8.8, 5.6 дахь заалт, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Захиргааны зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн №03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш, эмч, сувилагч, ажилтан, албан хаагчдын сонгон шалгаруулалтын журмыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газрын дарга (Б.Янжмаа), Багшийн хөгжил, цахим сургалтын газрын дарга (Г.Батбаатар) нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Б.Зоригтбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Н.ХҮРЭЛБААТАР

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн  
Захирлын 2023 оны 06 дугаар сарын 25-ны  
өдрийн 447-дугаар тушаалын хавсралт

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш, эмч, сувилагч,  
ажилтан, албан хаагчдын сонгон шалгаруулалтын журам

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль (цаашид "АШУҮИС" гэх)-ийн ажлын байрны шаардлага хангасан багш, эмч, сувилагч, ажилтан, албан хаагчдыг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Багш, эмч, сувилагч, ажилтан, албан хаагчдыг сонгон шалгаруулахдаа Хөдөлмөрийн тухай хууль, АШУҮИС-ийн Хөгжлийн бодлого-2030, Хөдөлмөрийн дотоод журам, болон бусад холбогдох хууль тогтоомжийг баримтална.
- 1.3. Сонгон шалгаруулалтад хууль дээдлэх, шударга, ил тод, авлига, ашиг сонирхлоос ангид байх, нээлттэй өрсөлдөөний зарчмыг баримтлах ба нэр дэвшигчийг үндэс, угсаа, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн сонирхол зэргээр нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно.
- 1.4. Сонгон шалгаруулалтын бодлого нь мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай, зөв харилцаа хандлагатай, ёс зүйтэй, нийгмийн идэвхтэй, бүтээлч, гадаад хэлний мэдлэгтэй, багаар ажиллах чадвартай багш, ажилтан, мэргэжилтнийг сонгоход чиглэнэ.
- 1.5. Сонгон шалгаруулалтад нэр дэвшигчийн мэдлэг, ур чадвар, хандлага, ёс зүйг бодитоор үнэлэхүйц аргыг ашиглана.

### Хоёр. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

- 2.1. АШУҮИС-ийн ажлын байрны сонгон шалгаруулалт нь дараах хэлбэртэй байна.
  - 2.1.1. Багшийн сонгон шалгаруулалт;
  - 2.1.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сонгон шалгаруулалт;
  - 2.1.3. Багш бэлтгэх тусгай хөтөлбөрийн сонгон шалгаруулалт;
- 2.2. Гадаадын их сургуульд багшилж байсан туршлагатай, эрдмийн зэрэг, цолтой багш, мэргэжлийн мэдлэг, ур чадвартай эмч, судлаач, мэргэжилтэнтэй хөдөлмөрийн гэрээг шууд байгуулж болно.
- 2.3. АШУҮИС-ийн бүрэлдэхүүн болон салбар сургуулиуд, эмнэлэг, газар, нэгжүүд шаардлагатай ажлын байрны саналаа жил бүрийн 06 дугаар сарын 25, 11 дүгээр сарын 25-ны өдөрт багтаан Захиргаа, хүний нөөц газарт ирүүлнэ.
- 2.4. Багш, эмч, сувилагч, ажилтан албан хаагчдын сонгон шалгаруулалтыг жил бүрийн 8 дугаар сарын сүүлийн хагаст зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд хичээлийн жилийн 2 дугаар улирлын эхэнд сонгон шалгаруулалт зарлаж болно.

### Гурав. Сонгон шалгаруулалт

- 3.1. Багш сонгон шалгаруулах

3.1.1 Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газар тэнхимүүдийн цагийн ачааллыг тооцож, шаардлагатай багшийн тоог гаргана.

3.1.2 Ерөнхий болон анагаахын суурь шинжлэх ухааны тэнхимд багш сонгон шалгаруулахад дараах ерөнхий шаардлага тавина.

3.1.2.1 Магистр, түүнээс дээш зэрэгтэй байх;

3.1.2.2 Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх;

3.1.2.3 Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх;

3.1.3 Эмнэлзүйн тэнхимд багш сонгон шалгаруулахад дараах ерөнхий шаардлага тавина.

3.1.3.1 Магистр, түүнээс дээш зэрэгтэй байх;

3.1.3.2 Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх;

3.1.3.3 Мэргэшүүлэх сургалтыг дүүргэсэн байх;

3.1.3.4 Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх;

3.1.4 Багш сонгон шалгаруулалтад оролцогчид дараах материалыг бүрдүүлнэ.

3.1.4.1 Төрийн албан хаагчийн анкет

3.1.4.2 Боловсролын дипломын (Бакалавр, магистр, докторын) хуулбар

3.1.4.3 Мэргэшсэн байдал (Мэргэжил дээшлүүлсэн гэрчилгээ, эмчлэх эрхийн гэрчилгээ гэх мэт)

3.1.4.4 Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт

3.1.4.5 Иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын хуулбар

3.1.5 Багшийн сонгон шалгаруулалтыг сорилын шалгалт, ярилцлага гэсэн үе шаттай зохион байгуулна.

3.1.6 Сорилын шалгалт нь 100 асуулттай байх ба мэргэжил (50%), англи хэл (30%), ёс зүй (20%) гэсэн бүтэцтэй байна.

3.1.7 Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн англи хэлний онооны батламжтай бол шууд тооцно.

3.1.8 Сорилын шалгалтад 75-аас дээш хувийн үнэлгээ авсан тохиолдолд ярилцлага шалгаруулалтад орно.

3.1.9 Ярилцлага шалгаруулалтад дэд захирлууд, холбогдох газрын дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч оролцох ба шалгуур хуудасны дагуу үнэлгээ өгч сонгон шалгаруулна.

3.1.10 Шинээр ажилд орж буй нэр дэвшигч дадлагажигч багшийн зэрэглэлд ажиллах (2.2 дахь заалтад хамаарахгүй) ба хөдөлмөрийн гэрээ байгуулах саналыг Захиргаа, хүний нөөцийн газарт танилцуулж, АШУҮИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

3.2. Эмч, сувилагч болон бусад мэргэжилтэн, ажилтныг сонгон шалгаруулах

3.2.1. Салбар, нэгжийн удирдлага нь шаардлагатай ажлын байранд ажилтан, албан хаагч шалгаруулж авах хүсэлтээ Захиргаа, хүний нөөцийн газарт гаргана.

3.2.2. Захиргаа, хүний нөөцийн газар нь ажлын байранд тавигдах шаардлагын дагуу сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд нээлттэй зарлана.

3.2.3. Эмч, сувилагч, тусгай мэргэжилтний сонгон шалгаруулалтад оролцогчид дараах материалыг бүрдүүлнэ.

3.2.3.1. Төрийн албан хаагчийн анкет



- 3.2.3.2. Боловсролын дипломын (Бакалавр, магистр, доктор) хуулбар
- 3.2.3.3. Мэргэшсэн байдал (Мэргэжил дээшлүүлсэн гэрчилгээ, эмчлэх эрхийн гэрчилгээ гэх мэт)
- 3.2.3.4. Иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын хуулбар
- 3.2.3.5. Өмнөх ажил олгогчийн тодорхойлолт
- 3.2.4. Сонгон шалгаруулалт нь Захиргаа хүний нөөцийн газар бичиг баримтын бүрдэлд анхан шатны үнэлгээ өгөх, нэр дэвшигчтэй ярилцлага хийх, шийдвэр гаргах гэсэн үе шаттай байна.
  - 3.2.4.1. Захиргаа, хүний нөөцийн газар нь ажлын байрны нээлттэй зарын дагуу ирүүлсэн нэр дэвшигчийн бичиг баримтын бүрдэлд үнэлгээ хийж тэнцсэн тохиолдолд тогтоосон өдөр, цагт ярилцлагад урина.
  - 3.2.4.2. Нэр дэвшигчтэй хийх ярилцлагад нэгж, газрын удирдлага оролцох ба нэр дэвшигчийн мэргэжлийн ур чадвар, ёсзүй, харилцаа хандлага, багаар ажиллах чадвар зэрэгт шалгуур хуудасны дагуу үнэлгээ өгч сонгон шалгаруулна.
  - 3.2.4.3. Ажлын байранд тавигдах шаардлагаас хамааран мэргэжлийн ур чадварыг тодорхойлох шалгалтыг авч болно.

### 3.3. Багш бэлтгэх тусгай хөтөлбөрт сонгон шалгаруулах

- 3.3.1. АШУҮИС-ийн бакалаврын хөтөлбөрийг голч дүн 3.4 буюу түүнээс дээш дүнтэй төгссөн, нийгмийн идэвх өндөр, багаар ажиллах чадвартай шилдэг төгсөгчдийг багшийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор сонгон шалгаруулна.
- 3.3.2. Сонгон шалгаруулалтад тэнцсэн төгсөгчдийг магистрын сургалтад элсүүлж, АШУҮИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг олгох ба багш бэлтгэх тусгай хөтөлбөрт хамруулж, мэргэжлийн тэнхим дээр дагалдан суралцуулж, дадлагажуулна

Дөрөв. Бусад

- 4.1 Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах ажлыг Захиргаа, хүний нөөцийн газар хариуцна.
- 4.2 Журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээнэ.



-----oooOooo-----

